



## ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ӨВА-2026/05-14-ШТА-НА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА

## ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Энэхүү аудитын тайлантай холбоотой  
нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна  
уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)





# ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН



**АУДИТААР 2,637.5 САЯ ТӨГРӨГИЙН 8 АЛБАН ШААРДЛАГА, 2 ЗӨВЛӨМЖ ӨГЧ, 2,584.0 САЯ ТӨГРӨГИЙН САНХҮҮГИЙН ҮР ӨГӨӨЖ, 1 САНХҮҮГИЙН БУС ҮР ӨГӨӨЖ ТООЦОВ**

**АЛБАН ШААРДЛАГА - 8**

**ЗӨВЛӨМЖ - 2**


**ҮР ӨГӨӨЖ - 2,584.0 сая**

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ



Орон нутгийн төсвийн 2025 оны хөрөнгө оруулалтаар 5,147.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээ баталсан.

Төсвийн жилд шинээр хэрэгжүүлэхээр 2,926.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14 төсөл, арга хэмжээ баталсан.



- Тоног төхөөрөмж - 13%
- Их засвар - 54%
- Авто зам - 6%
- Бусад - 27%

Нийт төсөл, арга хэмжээний 13 хувийг тоног төхөөрөмж, 6 хувийг авто зам, 54 хувийг их засвар, 28 хувийг бусад салбарт хөрөнгө оруулахаар төлөвлөжээ.



Их засвар - 20  
1,980.9 сая



Автозам засвар, арчлалт - 1  
200.0 сая




Тоног төхөөрөмж - 2  
455.0 сая



Хөрөнгө оруулалтын бус - 1  
1,000.0 сая

## Өвөрхангай аймагт 2023-2025 онуудад ОНТХО - аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ





# ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2025 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

## БҮЛЭГ 1



ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ НЬ ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ БАЙНА.



**Бодлогын баримт бичигтэй  
уялдаагүй ТАХ - 2  
1,268.5**

**Шалгуур үзүүлэлтээр  
эрэмбэлээгүй ТАХ - 7  
2,045.7**



**Төлөвлөлтийн шаардлага  
хангаагүй ТАХ - 5  
1,039.1**



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний жагсаалтад хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдсан, нэн тэргүүнд хэрэгцээ, шаардлагатай, Төсвийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан ТАХ-г тусгах шаардлагатай байна.

## БҮЛЭГ 2



ДҮГНЭЛТ: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖИХ ЗАРИМ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ГҮЙЦЭТГЭГЧ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖИЛЛАГААГ ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ЗААСАН ХУГАЦААНД ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА.

ТША	ТША	2025	2025	Зөрчил	Зөрчил
Нээлтэй тендер шалгаруулалтын арга	Харьцуулалтын арга	Амжилттай болсон ХАА	Амжилтгүй болсон ХАА	Эрх шилжүүлэх хугацааг баримтлаагүй	Хуульд заасан хугацааг баримтлаагүй
<b>ТАХ-10</b> 1,913.4 сая	<b>ТАХ-7</b> 587.8 сая	<b>ТАХ-13</b> 1,926.7 сая	<b>ТАХ-4</b> 574.5 сая	<b>ТАХ-2</b> 340.0 сая	<b>ТАХ-2</b> 220.7 сая



ОНТХО-аар хийгдэх 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2-д заасан хугацааг баримтлаагүй зөрчил илэрсэн.



### БҮЛЭГ 3



**ДҮГНЭЛТ: ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛТЭЙ УЯЛДУУЛАН САНХҮҮЖҮҮЛСЭН БАЙНА.**



Гүйцэтгэгч их засварын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжүүлсэн байна.

Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна.

**Техник, тоног төхөөрөмжийг техникийн тодорхойлолтын дагуу бүрэн нийлүүлсэн байна.**

№	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг
1	Арвайхээр сумын камерын хяналтын системийн засвар, арчилгаа тохируулгад ашиглах автовишк	2025	2025	34.9
2	Баянгол, Богд, Уянга сумдын Засаг даргын Тамгын газарт суудлын автомашин	2025	2025	414.3
Нийт				449.2

**Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлтэй уялдуулан санхүүжүүлсэн байна.**



Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн гүйцэтгэл сүүлийн 3 жилийн дунджаар 86.5 хувьтай байна.

9

**ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛААГУЙ ТАХ-9**



2

**НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ЗӨРҮҮТЭЙ ДҮНГЭЭР БҮРТГЭСЭН ТАХ-2**



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дараах 9 ТАХ-ний барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээнд зохиогчийн хяналтын зардлыг нийт 10.6 сая төгрөгийг тусгаж өгсөн боловч тухайн ажлуудын зохиогчтой гэрээг байгуулаагүй, хяналт хийгдээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.



Аймгийн ИТХ-ын 2026 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 12/01 дүгээр тогтоолоор бүртгэлд тусгах хөрөнгийн дүнг зөрүүтэй тогтоосноос дараах 2 ТАХ-г нягтлан бодох бүртгэлд зөрүүтэй тусгасан байна.




## АУДИТЫН ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлд тулгуурлан дараах дүгнэлтийг өгч байна.

Үүнд:



Өвөрхангай аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй 1,268.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь нийт төлөвлөсөн санхүүжилтийн 10.5 хувийг эзэлж байна.



Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ, ИТХ-ын ээлжит хуралдааны явцад нэмэлтээр 1,045.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ТАХ, нийт 7 ТАХ-г нэн тэргүүний ач холбогдол, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан эсэхийг эрэмбэлээгүй Өвөрхангай аймгийн 2025 оны төсөвт баталсан байна.



Төлөвлөсөн ТАХ-ээс 340.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх шилжүүлсэн сумдын Засаг нар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7 -д заасан хугацааг баримтлаагүй байна.



Зарим төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хугацаанд зохион байгуулаагүй байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн их засварын ажлыг батлагдсан зураг төсвийн дагуу хэрэгжүүлж, автомашин, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээнүүд техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт туссан үзүүлэлт, тоо хэмжээний дагуу нийлүүлсэн байна.



Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх дараах 9 ТАХ-ний барилгын засварын ажил гүйцэтгэх гэрээнд зохиогчийн хяналтын зардалд нийт 10.6 сая төгрөгийг тусгаж өгсөн боловч тухайн ажлуудын зохиогчтой гэрээг байгуулаагүй, хяналт хийгдээгүй, санхүүжилт олгогдоогүй байна.



Нягтлан бодох бүртгэлд 4 их засварын ажлын төсөвт өртгийг зөрүүтэй бүртгэсэн байна.